



ЭХ БАРИГЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний хуралд 3 ба түүнээс дээш илтгэл, хэлэлцүүлж, хэвлүүлсэн байх /Бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг хавсаргана/;
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх ба үүний 1,5-аас доошгүй багц цагийг сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдаж албан ёсны гэрчилгээ авсан байх;
3. Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд хүн хүч, цаг хугацаа хэмнэсэн, ажил хөнгөвчилсөн эмчилгээ, үйлчилгээнд үр дүнтэй нь батлагдсан, байнга хэрэгжих боломжтой 3-аас доошгүй шинэ санаа, тэргүүн туршлага нэвтрүүлсэн байх /зургаар баримтжуулсан тайлан/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний хуралд 4 ба түүнээс дээш илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлсэн байх /Бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг хавсаргана/;
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх ба үүний 2-оос доошгүй багц цагийг сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагдаж албан ёсны гэрчилгээ авсан байх;
3. Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд хүн хүч, цаг хугацаа хэмнэсэн, ажил хөнгөвчилсөн эмчилгээ, үйлчилгээнд үр дүнтэй нь батлагдсан, байнга хэрэгжих боломжтой 3-аас доошгүй шинэ санаа, тэргүүн туршлага нэвтрүүлсэн байх /Зургаар баримтжуулсан тайлан/;
4. Шинээр төгсөж ирсэн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцаж буй 5-аас доошгүй эх баригчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх

- /байгууллагын тодорхойлолтод дадлагажуулсан хүний нэр,
дадлагажуулсан хугацааг тусгасан байна/;
5. Хэвлэлд мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй зөвлөмж, нийтлэл, бүтээл
нийтлүүлсэн байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг
хангасан байна. Үүнд:

1. Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
2. Багц цагийн биелэлтийн шаардлагыг бүрэн хангаж, сүүлийн 3 жилд тус бүр
3 багц цагийн сургалтад хамрагдсан байх ба үүний 2-оос доошгүй багц
цагийг сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/
зохион байгуулсан мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагдаж албан ёсны
гэрчилгээ авсан байх;
3. Эрдэм шинжилгээний хуралд 5 ба түүнээс дээш илтгэл хэлэлцүүлж,
хэвлүүлсэн байх ба бүтээлийн жагсаалт, илтгэлийн хураангуй, хөтөлбөрийг
хавсаргах /үүнээс олон улсад 1-ээс доошгүй/;
4. Эх барих, нярайн яаралтай тусlamжийн чиглэлээр сургагч багшийн
сургалтад хамрагдсан, бие дааж дадлага сургалт зохион байгуулсан байх
/тайлан, баримтжуулалт, бодит үр дүн/;
5. Мэргэжлийн чиглэлээр үндэсний хэмжээнд судалгааны ажил, төсөл,
хөтөлбөр хэрэгжүүлсэн, тухайн багт үүрэгтэйгээр оролцсон байх;
6. Эх,хүүхдийн тусlamж үйлчилгээний чиглэлээр олон нийтэд таниулах
нөлөөллийн ажил /уулзалт, сургалт, хэлэлцүүлэг/ санаачлан зохион
байгуулсан, эсвэл зохион байгуулах багт үүрэгтэйгээр оролцсон байх ;
7. Мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл бүхий ном, товхимол, зөвлөмж,
гарын авлага, видео хийж олон нийтэд таниулсан байх;
8. Мэргэжлээрээ олон улсын хурал, сургалтад оролцсон байх /гэрчилгээ/
9. Хувь хүний хөгжлийн сургалтаар ярих, илтгэх, зөвлөгөө өгөх, манлайлах ур
чадварыг эзэмшсэн байх /гэрчилгээ/;
10. Сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан.